



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 25

Номгон

Аймгийн төвийн багуудын хилийн цэсийг  
өөрчлөх, шинэ суурьшлын бүсийг төлөвлөх, нэршлийг  
шинэчлэн тодотгох ажлыг судалж, санал, дүгнэлт  
гаргах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хаягжуулалтыг шинээр хийх болсонтой холбогдуулан аймгийн төвийн багуудын хилийн цэсийг өөрчлөх, шинэ суурьшлын бүсийг төлөвлөх, нэршлийг шинэчлэн тодотгох ажлыг судалж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхсоёл-Баянхонгор сумын Засаг дарга

Т.Норов-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

П.Рэнцэнпэлжээ-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,  
Тэргүүлэгч

С.Готов-Хот тохижилт ОНӨҮГ-ын дарга

С.Хүрэлхуяг-Аймгийн ерөнхий архитектор

Т.Отгонбаатар-“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний захирал

С.Идэрцэцэг-“Чандмань-Баянхонгор” ХК-ний ерөнхий инженер

Б.Баярсайхан-“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨК-ний захирал

Ц.Уянга-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Газрын асуудал хариуцсан  
Улсын байцаагч

В.Наранчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын  
хэлтсийн мэргэжилтэн

Х.Баасанжаргал-Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын газрын  
мэргэжилтэн

116395

Г.Амгаланбаатар-Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын архитектор  
Багийн Засаг дарга нар

2.Хилийн цэсийг өөрчлөх, шинэ суурьшлын бүсийг аймгийн ерөнхий  
төлөвлөгөөний дагуу төлөвлөх, нэршлийг шинэчлэн тодотгох ажлын хэсгийн санал,  
дүгнэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /Ж.Мөнхсоёл/-т  
даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР